



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот


### Ахисан түвшний сургуулийн үйл ажиллагааг зохицуулах тухай

МУИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 9 дүгээр тогтоол, хурлын шийдвэр, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн хурлын шийдвэр, МУИС-ийн Дүрмийн 4.3.1, 4.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахисан түвшний сургуулийн бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Ахисан түвшний сургуулийн ажилтнуудын Албан тушаалын тодорхойлолтыг 2020 оны 09 дүгээр сарын 1-ний өдрийн дотор шинэчлэн батлуулж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахыг Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Ахисан түвшний сургуулийн захиргааны зөвлөлийг ахисан түвшний сургалт эрхэлдэг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлуудын бүрэлдэхүүнтэйгээр хоёрдугаар хавсралтын дагуу зохион байгуулсугай.
4. Бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хорооны чиг үүрэгтэй ижил түвшний Ахисан түвшний хөтөлбөр хариуцсан хорооны ажиллах удирдамжийг боловсруулан албажуулж, бүрэлдэхүүнийг 2020 оны 10 дугаар сарын 01-ний дотор эмхлэн байгуулахыг Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/, Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Д.Бадмаанямбуу/ нарт үүрэг болгосугай.
5. МУИС-д ажиллаж байгаа судалгааны лабораториудыг Ахисан түвшний сургуулийн харьяалалд 2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс шилжүүлэн ажиллуулахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан дэд захирал /Ч.Лодойравсал/, Санхүү, төлөвлөлт хариуцсан дэд захирал /Б.Энх-Амгалан/, Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/ нарт тус тус үүрэг болгосугай.
6. Ахисан түвшний сургуулийн захиралд МУИС-ийн Дүрэмд заасан эрх үүргээс гадна дараах зарим эрх үүргийг шилжүүлсүгэй. Үүнд: Ахисан түвшний суралцагсдын ганцаарчилсан төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, эрдэм шинжилгээний ажлын сэдэв батлах, удирдагчийг томилох, эрдэм шинжилгээний багц цаг тооцох зэрэг ажлуудыг хөтөлбөрийн харьяалагдах тэнхимүүдтэй хамтран зохион байгуулах, сургалтын болон судалгааны тэтгэлэг олгох, судалгааны туслахаар ажиллуулах, пост докторын тэтгэлэг олгох.
7. МУИС-ийг түшиглэн байгуулагдсан Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хамгаалах докторантуудын материалд хянан магадалгаа хийж дүгнэлт гаргах үүргийг Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/-д хариуцуулсугай.
8. Судалгааны суурь зардлын хуваарилалт, эрдэм шинжилгээний багц цагийн төлбөр тооцоо, суралцагчдын судалгааг дэмжих санхүүжилт, тэтгэлгийн хуваарилалт, зарцуулалт зэрэг санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах үүргийг Ахисан түвшний сургуулийн захирал /Н.Баатарбилэг/-д даалгасугай.
9. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ОЧИРХУЯГ



3340301884